



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 1/511

Арвайхээр

Отрын штаб байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд 2020-2021 оны өвөл, хавар өөрийн аймгийн сум хооронд болон зэргэлдээ аймгийн нутагт отроор өвөлжиж байгаа малчдад эрүүл мэнд, нийгэм, төрийн үйлчилгээг зохицуулах "Аймгийн отрын штаб"-ыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаар холбогдох судалгаа, мэдээллийг нарийвчлан гаргаж, малчдын сургуулийн насны хүүхдийг тухайн очсон сумдын сургуульд хамруулах, хүн, мал эмнэлэг, соёл, холбоо мэдээлэл, төрийн үйлчилгээгээр үйлчлэх асуудлыг сумдын удирдлагуудтай хамтран зохицуулж, малчдыг тав тухтай өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээ авч ажиллахыг "Аймгийн отрын штаб" (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Аймгийн отрын штаб ажил үүргээ гүйцэтгэхэд зарцуулах түлш шатахуун, хоол, холбоо мэдээлэл болон бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Нэмэхбаяр/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101139

Аймгийн Засаг даргын 2020 оны.....
дүгээр сарын.....ны өдрийн.....
дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ОТРЫН ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Штабын дарга: И.Доржсүрэн -аймгийн Засаг даргын орлогч
Штабын орлогч дарга: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,
хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд: Г.Баясгалан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төвөвлөлтийн хэлтсийн дарга
Д.Одонбаяр -аймгийн Онцгой байдлын газрын дарга
Д.Шивааннүрдэв -аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн
газрын дарга
О.Ганбат -аймгийн Цагдаагийн газрын дарга
С.Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын дарга
Ж.Пүрэвсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл
урлагийн газрын дарга
Ч.Гүнсэнхорол -аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга хот байгуулалтын газрын дарга
Б.Оюунчимэг -аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны
шинжилгээний газрын дарга
А.Нямдаваа -аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
Н.Гуамарал -аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл,
олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө
аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

-оОо-